

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 04-р сарын 18 өдөр
сум

Хархорин

“Хархорин” нээлттэй ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 04-р сарын 18-ны өдөр 14 цаг 00 минутад Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэ толгой баг, Усжуулахын контор хаягаар байрлах Хархорин ХК-ийн хурлын танхимд эхлэв.

Хуралд байлцсан: Хувьцаа эзэмшигчид

1. П.Учрал – (377,660 ш хувьцаа эзэмшигч С.Пүрэвийг итгэмжлэлээр төлөөлж оролцов).
2. Д. Дашмаа- Ерөнхий нягтлан бодогч, Хувьцаа эзэмшигч (100 ширхэг хувьцаатай)
3. Ц. Баасансүрэн-Хувьцаа эзэмшигч (100 ш)
4. Ч. Отгонсүрэн- Хувьцаа эзэмшигч (93 ш)
5. Ц. Бүрэнжаргал- Хувьцаа эзэмшигч (93 ш)

Хуралд байлцсан бусад хүмүүс:

1. Б.Амарсанаа- Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга
2. Р.Саранцэцэг-Гүйцэтгэх захирал
3. Б. Ганбат –Хурал зохион байгуулах комисс
4. М.Шавагцэрэн-Тооллогын комиссын дарга
5. Э.Ариунаа-Тооллогын комиссын гишүүн
6. Л.Бямбасүрэн-Ерөнхий агрономич
7. Өлзий-Орших – Эдийн засагч

Түүнчлэн компанийн бусад ажилтан ажиллагсад оролцсон болно.

Хурлын ирц: Нийт 539,515 ш хувьцаа эзэмшиж байгаа 576 хувьцаа эзэмшигч хуралд оролцохоос 378,046 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшиж байгаа 5 хувьцаа эзэмшигч хуралд оролцож, хурлын ирц 70.07 % болсон.

Хурлаар хэлэлцсэн асуудлууд:

1. Компанийн 2017 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн 2017 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг хэлэлцэн батлах;
4. Компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах;

Хэлэлцсэн байдал:

Тооллогын комиссын зүгээс хурлын ирцийг танилцуулсан болно.

Хархорин ХК-ийн Хувьцаа эзэмшигчидийн ээлжит хуралд нийтдээ 539,515 ш хувьцаа эзэмшиж байгаа нийт 576 хувьцаа эзэмшигч ирэхээс 378,046 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 5 хувьцаа эзэмшигч ирсэн байна. Компаний саналын эрх бүхий нийт хувьцааны 70.07 %-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн. Иймд компаний тухай хууль болон компаний дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөр гэж үзэхэд хангалттай тухай тооллогын комиссын зүгээс мэдэгдэв.

Үүний дараагаар "Хархорин" ХК-ийн 2018 оны 4-р сарын 18 өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг тус хурлын дарга Б.Амарсанаа нээж үг хэлсэн ба хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлууд, эдгээр асуудлуудыг танилцуулах ажилтнуудыг танилцуулав.

(Хурлын дэгийг хавсаргасан болно)

Хурлын дарга хуралд хүрэлцэн ирсэн албан тушаалтнууд, хувьцаа эзэмшигчдийг танилцуулав.

Түүнчлэн тооллогын комиссын зүгээс санал хураалт хэрхэн явагдах, саналын хуудсаар хэрхэн саналаа өгөх талаар хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

1-р асуудал: Компанийн 2017 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Компанийн 2017 оны үйл ажиллагааны тухай ТУЗ-ийн тайланг "Хархорин" ХК-ийн Ерөнхий агрономч Л.Бямбасүрэн уншиж танилцуулсан болно.

(Тус тайланг бүрэн эхээр нь Хархорин ХК-ийн 2018 оны 4-р сарын 18 өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолд хавсаргасан болно)

Танилцуулсан байдал:

Л.Бямбасүрэн: Сайн байцаана уу? Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Ингээд 2017 оны үйл ажиллагааны тухай тайланг уншиж танилцуулъя.

2016 – 2017 оны өвөл манай талбайд бага зэргийн буюу 3 – 5 см зазаан цастай өвөлжсөн. Мөн хавартаа чийг сайтай байснаас шалтгаалан хавар чацарганы жимст цэцэрлэгт чацарганы болон бусад жимст модлог ургамлуудад жимс сайн суусан. 4-р сарын 19-нд 2 – 3 мм хэмжээтэй, 4-р сарын 22-нд 5 – 7 мм хэмжээтэй, 5-р сарын 4-нд 2 мм хэмжээтэй, 5-р сарын 20 –нд 12 – 14 мм хэмжээтэй буюу 2017 оны хавартаа 2 мм –с 14 мм хэмжээтэй цас үе үе орж хүйтэрсэн нь суулгац гаргалт, усалгаа зэрэг ажлуудад нилээд бэрхшээл учруулж байв. Тухайлбал 5-р сарын 20-нд орсон их хэмжээний нойтон цас 2 – 3 хоногийн турш өдөртөө болон шөнөдөө -3 -аас -8 °С хүрч хүйтэрснээс шалтгаалан үхэр нүд, далан хальс, алим, бөөрөлзгөнө зэрэг жимст модлог ургамлуудын цэцэг нийлэнхүйдээ хөлдөж гөвөгдөж унаснаас шалтгаалан дээрх ургамлууд бараг жимслээгүй.

Мөн 2017 оны 5-р сарын 22 –оос 7-р сарын 20 хүртэл нийтдээ 60 шахам хоног үргэлжилсэн хөрсний болон агаарын хавсарсан гангаас шалтгаалан чацарганы модонд хавар сайн суусан жимс маш их хэмжээгээр модон дээрээ хатаж, хорчийн гөвөгдөж унасан. Энэ 2017 он нь 1900 оноос хойшхи зундаа хамгийн их халсан хоёрдахь жил болж бүртгэгдсэн байна.

Мөн олон жилийн дунджаас бага хэмжээтэй хур тунадастай байсан нь энэ жил чацарганы болон бусад жимсний хувьд маш бага хэмжээний ургац авах нөхцөлд хүргэсэн.

8-р сарын 1-нд 12 минут орсон аадар борооноос үүдэлтэй үерээс шалтгаалан усалгаа 10 гаруй хоног саатсан.

Намар 10-р сард нийлээд хэмжээний цас орж хэсэг хүйтрээд цаашдаа 11, 12-р сард дулаахан байсан.

Энэ жил манай усалгааны цементэн, төв сувгийн ёроолын лаг шавар харьцангуй гүехэн байсан. Иймд сувгийн лаг шавар нь гүн хэсгийг техникээр хусаж аваад нийт бригадуудын ажилчидын хүчээр нэг өдрийн хугацаанд сувгийн хогийг хөнгөн хамуулж аваад сувгийн усыг тавьсан.

4-р сарын 22-нд сувагт ус өгч эхлэсэн ба 23-нд усалгааны газар доорх төв системээр ус урсган угаагаад, 23-ны шөнө системийн төв шугамуудыг усаар дүүргээд 24-с эхлэн жимст цэцэрлэгийн талбайн усалгаа эхлэсэн.

Агроүйлдвэрлэлийн 7 бригадын 211,78 хүн/өдөр хүчээр 1024342 ширхэг ногоон мөчрийг жимст цэцэрлэгээс хайчлуулан идэвхижүүлэгч бүхий уусмалтай хувинд хийлгэн авчруулаад, 120,8 хүн/өдөр хүчээр 1021290 ширхэг ногоон мөчрийг хүлэмжний гаднах бэлтгэсэн сүүдэрт зумлуулж, тоолуулж, идэвхижүүлэгчид хийлгээд, 131,1 хүн/өдөр хүчээр 1021398 ширхэг ногоон мөчрийг хүлэмжинд тариалуулсан.

Мөн хугацаанд 2-р бригадын хүлэмж хариуцсан цэцэрлэгчидээр ногоон мөчир дүрэх спиртэн уусмал найруулах, савлах, ногоон мөчир пад тракторын чиргүүлд ачих, буулгах ажил хийлгэсэн.

5-р сарын 20 –с 10-р сарын 30-ны хооронд 5-р бригадын хүлэмж хариуцсан дөрвөн (7-р сараас гурав болсон) цэцэрлэгчидийн 720 хүн/өдөр хүчээр хүлэмжний усалгаа, хүлэмжний засвар, усалгааны системийн засвар, хавар хүлэмжний услалтын систем угсрах, намар задалж хураах, хаалт угсрах, форсунк шахах, аваарын дизель мотор ажиллуулах, хүлэмжний засварын ажил, хүлэмж хоорондын зэрлэгийг гараар зулгаан авч цэвэрлэх, хүлэмжний хашааг засаж барих зэрэг хүлэмжний ажлууд хийлгэв.

Хавар 130915 ш чацарганы, 408 ш үхэр нүдний, 1154 ш улиасны, 33134 ш хайлаасны, 18 ш бөөрөлзгөний, 120 ш шар хуайсны, 14 ш гүзээлзгэний буюу нийт дүнгээрээ 165753 ш суулгац, намар 107158 ш чацарганы, 46 ш үхэр нүдний, 520 ш улиасны буюу нийт дүнгээрээ 107724 ш суулгац буюу жилийн нийт дүнгээрээ 273477 ш суулгац ухаж гарган дотооддоо нөхөн тариалалтанд болон гадагш тендерийн суулгац гаргасан.

Энэ жил 67,2 кг гүзээлзгэнэ жимс, бөөрөлзгөнө 5,5 кг, чацаргана 72824,6 кг–г тус тус хураан авч борлуулсан. Цаг агаарын тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалан алим, үхэр нүдний ургац гараагүй.

Хурал зохион байгуулах комиссын гишүүн Б.Ганбат: Асуудал тус бүрийг уншиж танилцуулсны дараагаар Хувьцаа эзэмшигч та бүхэн өөрсдийн асуулт, санал, шүүмжлэлээ, мөн компанийн гүйцэтгэх захирал, ерөнхий агрономч, ерөнхий нягтлан бодогч нараас асууж тодруулж болно.

Иймд үйл ажиллагааны тайлантай холбоотойгоор та бүхний зүгээс асуух, тодруулах зүйл байна уу? Санал, шүүмжлэл байна уу?

П.Учрал: Хүлэмжинд тарьсан эр мод эм модны харьцуулалтын тухай асуув.

Л.Бямбасүрэн: 12 хүлэмжинд эм мод, 8 хүлэмжинд эр мод тарьсан.

П.Учрал: талбайд гарсан хортон шавьжийг яаж устгах тухай асуув.

Л.Бямбасүрэн: Органик жимс үйлдвэрлэхийн тулд химийн хор хэрэглэхгүйг хичээж байгаа. Гэхдээ их гарсан тохиолдолд хэрэглэхээс өөр арга байхгүй. Өнгөрсөн 2017 онд оросын модны талбайд бага зэрэг хор цацсан.

(Хувьцаа эзэмшигчдийн зүгээс санал, шүүмжлэл, асууж тодруулах зүйл гараагүй болно)

Б.Ганбат: Тэгэхлээр Хувьцаа эзэмшигч та бүхний зүгээс компанийн 2017 оны жилийн үйл ажиллагааны талаарх ТУЗ-с гаргасан дүгнэлттэй холбоотойгоор асуух, тодруулах зүйл, санал, шүүмжлэл байхгүй гэж үзлээ.

2-р асуудал: Компанийн 2017 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Тус асуудлыг нягтлан бодогч С.Нямхүү танилцуулсан болно.

(Тус тайланг бүрэн эхээр нь Хархорин ХК-ийн 2018 оны 4-р сарын 18 өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолд хавсаргасан болно)

С.Нямхүү: Хуралд ирсэн та бүхний амрыг айлтгая.

С.Нямхүү: Жилийн эцсийн баланс болон үндсэн хөрөнгөнд нэмж бүртгэсэн материалуудын талаар хэлэв. Мөн хангамжийн материал, түлш гэх мэт орлогдож авсан бараа материал хэрхэн зарлагадсан талаар тайлан тавив. Гаднаас авах авлага болон өглөгийг хувь хүн албан байгууллагаар нь тус тус ангилсан байна.

2017 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайланг 2017.01.01-2017.12.31-ний байдлаар өссөн дүнгээр Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж заавар журам, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж тайлан хүлээн авах эрх бүхий газруудад хуулийн хугацаанд хүргүүлэн ажилладаг болно. Түүнчлэн хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид нь "Хархорин" ХК-ийн санхүүгийн тайлантай Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас танилцах боломжтой.

"Хархорин ХК-ийн 2017 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт хөрөнгө 2017 оны эхэнд 7,554,774,6 мян төг, байсан бол жилийн эцсийн байдлаар 8,279,839,1 мян төг болж 9,5% өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант жилийн Борлуулалтын нийт орлого: 1,219,794,3 мян төг

Борлуулалтын нийт өртөг : 975,970,9 мян төг

Борлуулалтын ашиг : 243,823,4 мян төг

Үйл ажиллагааны бус орлого: 3,593,0 мян төг

Удирдлагын зардал : 210,619,2 мян төгрөгийг хасч тооцоод 36,797,2 мян төгрөгийн татварын өмнө ашигтай ажилласан. ААН-ийн орлогын албан татварт 3,197,5 мян төг тооцогдож татварын дараах цэвэр ашиг 33,599,7 мян төгрөг болсон.

2017 онд байгаль цаг уурын хүндрэлтэй байдлаас шалтгаалж /бороо , хур ороогүйгээс / 768 тн ургац авахаар төлөвлөсөн боловч 61,3 тн ургац хураан авч үндсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа алдагдалтай ажилласан болно.

П.Учрал. үндсэн хөрөнгө актлахдаа элэгдэл хорогдол яагаад тооцоогүй вэ?

Д.Дашмаа: Элэгдэл хорогдол тооцож ажилладаг. Үндсэн үнээс хорогдол тооцсон дүнгээ салгаж бичээгүй байгаа.

Б.Амарсанаа: Компанийн санхүүгийн тайлантай холбоотойгоор хувь эзэмшигчдээс асууж тодруулах зүйл байна уу?

(Хувьцаа эзэмшигчдийн зүгээс санал, шүүмжлэл, асууж тодруулах зүйл гараагүй болно)

3-р асуудал: Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг хэлэлцэн батлах тухай

Энэ асуудлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга бөгөөд хурал зохион байгуулах комиссын дарга Б.Ганбат уншиж танилцуулав.

Б.Ганбат: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02-р сарын 14 өдрийн 01/2018 тоот тогтоолын дагуу “Хархорин” ХК нь 2017 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. (ТУЗ-ийн тогтоолыг бүрэн эхээр нь уншиж танилцуулав)

“Хархорин” компани нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дагуу 33.599.7 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан боловч компани нь ногдол ашиг хуваарилсан тохиолдолд төлбөрийн чадваргүй болохоор байгаа, түүнчлэн компани нь төлж барагдуулах шаардлагатай ихээхэн хэмжээний өр төлбөртэй байгаатай холбогдуулан 2018 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. Компанийн тухай хуулийн дагуу компани нь ногдол ашиг төлсний дараа төлбөрийн чадвартай байхаар заасан байдаг. Өнөөдөр манай компанийн санхүүгийн нөхцөл байдал сул байгаа, ихээхэн хэмжээний өр төлбөр хуримтлагдаад байна. Ажилчдынхаа цалинг тавих шаардлагатай байна. Та бүхэн эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэж ТУЗ-ийн ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг батлаж өгнө үү.

Б.Ганбат: Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-с гаргасан шийдвэрийг батлахтай холбоотойгоор та бүхний зүгээс асууж тодруулах зүйл байна уу? Санал, шүүмжлэл байна уу?

(Хувьцаа эзэмшигчдийн зүгээс санал, шүүмжлэл, асууж тодруулах зүйл гараагүй болно)

4-р асуудал: Компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах тухай

Компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Эдийн засагч А.Өлзий-Орших танилцуулсан болно. (Төлөвлөгөөг презентэйшн хэлбэрээр хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэд танилцуулсан болно; төс төлөвлөгөөг хурлын материалд хавсаргасан байгаа)

А.Өлзий-Орших: Манай компани монголдоо №1т орох чацаргана тариалах үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна. Мөн Мех баазын хашааг цементлэн барилга байгууламж барих, хиймэл нуур дуслын услалтын системийн мотор байрлуулах байр барих төлөвлөгөөтэй ажиллаж байна. Жимс жимсгэнэ, газар тариалангийн бүтээгдэхүүн нэмж тариалж ургац арвин авахын төлөө ажиллаж байна. Үүнд чацаргана 800 тн-г хураан авч Живэртийн оргил ХХК болон бусад байгууллагуудад нийлүүлнэ.

Агро үйлдвэрлэлд 175 хүн цэцэрлэгчээр ажиллуулж ажлын их ачаалалтай үе буюу жимс хураалтын үед ШШГА-болон бусад хамтран ажилладаг хувь хүн болон албан байгууллагуудтай хамтран ажиллана.

2018 онд үйл ажиллагаанд гарах зардал, хөрөнгө оруулалт хийх ажлуудыг товч танилцууллаа.

П.Учрал: жимс хураах зардлаа тооцсон уу?

Д.Дашмаа: Өмнөх жилийнхээсээ барагцаалж тооцоо гаргасан.

Л.Бямбасүрэн. жимс ургасан байгаа нь харагдах байдлаасаа өөрчлөгддөг. Энэ нь цаг агаарын байдал, услалт арчилгаагаас болж их өөрчлөгддөг талаар дэлгэрэнгүй тайлбарлан хэлэв.

Б.Амарсанаа: “Хархорин” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотойгоор хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч та бүхнээс асууж тодруулах зүйл байна уу? Санал, шүүмжлэл байна уу?

(Хувьцаа эзэмшигчдийн зүгээс санал, шүүмжлэл, асууж тодруулах зүйл гараагүй болно)

Б.Амарсанаа: Ингээд санал хураалтаа эхлүүлье.

Санал хураалтыг хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар авсан болно.

Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар өгсөн саналыг тоолох, тооллогын дүнг нэгтгэн шийдвэрээ гаргах хугацаанд хурал түр завсарласан болно.

Тооллогын дүн:

Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар өгсөн саналыг үндэслэн шийдвэрээ гаргаж хурлаар хэлэлцсэн асуудал тус бүрээр санал хураалтын дүнг танилцуулсан болно.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдээс авсан саналыг нэгтгэхэд дараах дүн гарсан болно. Үүнд:

1. Компанийн 2017 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудал – 100 хувийн саналаар батлагдав;
2. Компанийн 2017 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах – 100 хувийн саналаар батлагдав;
3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан

4. Компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах – 100 хувийн саналаар батлагдав;

Хурлаас гарсан тогтоолуудыг Б.Ганбат уншиж танилцуулав.

Хурлыг Хурлын дарга Б.Амарсанаа хаасан болно.

Хурал 17.10-д өндөрлөв.

Хурлаар шийдвэрлэсэн нь:

1. Компанийн 2017 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлав;
2. Компанийн 2017 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлав;
3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг хэлэлцэн зөвшөөрөв;
4. Компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлав;

ХУРЛЫН ДАРГА



Б.АМАРСАНАА

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20... оны ¹⁸...-р сарын ⁰⁴... өдөр

Дугаар ^{04/2018}...

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
даргыг шинээр томилох тухай

“Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит хурлын даргаар томилогдсон Пүрэвийн Бишрэл нь хүндэтгэн үзэх шалтгаанаар тус хурлыг даргалах боломжгүй болсонтой холбогдуулан Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5-ийг удирдлага болгон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Баатарын Амарсанааг шинээр томилсугай.
2. Тогтоол гарсантай холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Пүрэвийн Бишрэлийг компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит хурлын даргаас чөлөөлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



П.БИШРЭЛ